# ТЭЭВЭРЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

<table>
<tr><th colspan="2">Тээвэрлэгч компанийн бүрдүүлэх баримт бичиг<br>Шинээр гэрээ байгуулах хүсэлтийг (сар бүрийн 20-ноос 31-ний өдрүүдэд хүлээн авна)</th></tr>
<tr><td>1.</td><td>Авто тээврийн хариуцлагын гэрээ байгуулах тухай хүсэлт бүхий албан бичиг (албан бичигт чиглэлээ заавал тусгана.)<br>Тээврийн компанийн товч танилцуулга. Дараах мэдээллийг оруулсан байна. Үүнд:<br>- Үүсгэн байгуулсан огноо<br>- Үйл ажиллагааны чиглэл<br>- Хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч<br>- Захирал, Механик инженер, тээвэр зохицуулагч, бусад ажилтнуудын мэдээллийг доорх загварын дагуу
<table>
<tr><th>№</th><th>Овог</th><th>Нэр</th><th>Албан тушаал</th><th>И-мэйл хаяг</th><th>Утас</th></tr>
<tr><td>1</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>2</td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>2.</td><td>Улсын бүртгэлийн гэрчилгээ болон компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар; Үйл ажиллагааны чиглэлд авто машинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагаа байх.</td></tr>
<tr><td>3.</td><td>Механик инженер, тээвэр зохицуулагч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан мэргэжлийн ажилтан нь заавал үндсэн ажилтан байх бөгөөд диплом, мэргэшсэн үнэмлэхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, компанитай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хуулбар;</td></tr>
<tr><td>4.</td><td>Тээврийн хэрэгслүүдэд GPS суурилуулж, “ЭТТ” ХК-ийн цахим тээврийн GPS, RFID-ийн программтай холбогдсон байх;<br>(GPS-ийн гэрээний хуулбар ирүүлэх)</td></tr>
<tr><td>5.</td><td>Өөрийн эзэмшлийн эсхүл түрээсээр ашиглах кемп болон засварын газартай байх;<br>Өөрийн эзэмшил бол:<br>- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулсан байх;<br>- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар батлуулсан байх;<br>- Фото зураг;<br>Түрээсээр ашиглаж байгаа бол:<br>- Түрээсийн гэрээний хуулбарыг нотариатаар батлуулсан байх;<br>- Түрээслүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;<br>- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар;<br>- Фото зураг;</td></tr>
<tr><td>6.</td><td>Тээврийн компани 21-с доошгүй тээврийн хэрэгсэлтэй байх ба өөрийн эзэмшлийнх 10-аас доошгүй байх. Ирүүлэх материалын жагсаалт:<br>- Тээврийн хэрэгсэл, жолооч нарын жагсаалт<br>- Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа/АТҮТ-ийн эцсийн өмчлөгчийн лавлагаа/</td></tr>
</table>

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ

| | |
|---|---|
| | - Оношилгоо, техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл /Автотээврийн нэгдсэн системээс авах/<br>- Жолооч нарын мэргэшсэн жолоочийн үнэмлэхийн хуулбар |
| 7. | Ачаа тээвэр гүйцэтгэхэд тавигдах шаардлага хангаж буй авто тээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх; |
| 8. | Нийгмийн даатгалын тайлангийн сүүлийн 1 сарын тайлан баталгаажуулсан байх; /Механик инженер, тээвэр зохицуулагч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал хариуцсан ажилчид, өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийн жолоочтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан үндсэн ажилтан байх/ |
| 9. | “ЭТТ” ХК-ийн 8.2 км Зам ашиглах гэрээний төлбөрийн үлдэгдэлгүй байх; |

ЭТТ-ШИЛЭН КОМПАНИ